



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022/50/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Хэрлэнзаяа Утас: 70357955 Цахим хаяг: Kherlenzayao@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.24 № 83  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН 22 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
И.ОЛЗВОЙ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

22 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,974,640.00	46,478,410.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	43,974,640.00	46,478,410.00
351	Түүхий эд материал	38,912,130.00	43,053,700.00
3511	Тусгай зориулалттай материал	38,635,150.00	42,925,950.00
3513	Эм боох материал	276,980.00	127,750.00
354	Хангамжийн материал	5,062,510.00	3,424,710.00
3541	Бичиг хэргийн материал	25,000.00	101,000.00
3542	Аж ахуйн материал	842,000.00	463,500.00
3544	Түлш, шатах тослох материал	1,785,000.00	1,140,000.00
3546	Хүнсний материал	860,510.00	170,210.00
3547	Бусад хангамжийн материал	1,550,000.00	1,550,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	768,554,069.44	870,567,747.18
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	768,554,069.44	870,567,747.18
392	Биет хөрөнгө	672,754,694.37	774,905,872.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	630,245,495.00	727,066,517.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,115,134.28	-49,819,528.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,559,226.00	97,524,726.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,204,179.71	-30,483,867.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,146,149.63	98,146,149.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-57,876,862.27	-67,528,124.43
393	Биет бус хөрөнгө	95,799,375.07	95,661,875.11
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-415,624.93	-553,124.89
39303	Бусад биет бус хөрөнгө	95,490,000.00	95,490,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	812,528,709.44	917,046,157.18
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	812,528,709.44	917,046,157.18
51	Засгийн газрын хувь оролцоо	812,528,709.44	917,046,157.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,763,939.60	324,763,939.60

51101	Өмч: - төрийн	229,273,939.60	229,273,939.60
512	Хуримтлагдсан үр дүн	267,033,183.54	371,550,631.28
5121	Өмнөх үеийн үр дүн	267,033,183.54	267,033,183.54
5122	Тайлант үеийн үр дүн		104,517,447.74
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	220,731,586.30	220,731,586.30
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	812,528,709.44	917,046,157.18

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	558,636,700.00	696,955,322.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		141,817,922.00
120	Нийтлэг татварын бус орлого		141,817,922.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		137,786,522.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		4,031,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	558,636,700.00	555,137,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	514,169,500.00	511,980,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	514,169,500.00	511,980,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,250,000.00	940,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,250,000.00	730,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,217,200.00	42,217,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,217,200.00	42,217,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	590,293,815.41	592,437,874.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,293,815.41	592,437,874.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	570,122,721.63	583,616,587.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,931,199.86	424,236,547.00
210101	Үндсэн цалин	297,457,554.23	264,364,942.00
210102	Нэмэгдэл	81,079,044.86	123,370,227.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,311,858.77	1,172,395.60
210104	Урамшуулал	35,082,742.00	35,328,981.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,885,406.00	57,288,338.43
210201	Тэтгэврийн даатгал	38,460,703.03	41,646,821.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,143,326.69	4,381,567.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,314,635.00	2,995,320.66
210204	Ажилгүйдлийн даатгал	815,161.04	661,370.53
210205	Эрүүл мэндийн даатгал	8,151,580.24	7,603,258.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,444,330.36	35,155,338.14
210301	Гэрэл, цахилгаан	6,252,866.36	7,749,312.14

**Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	14,110,000.00	18,075,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,081,464.00	9,331,026.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,288,190.00	2,727,300.00
210401	Бичиг хэрэг	161,200.00	81,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	130,600.00	295,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,952,390.00	706,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,044,000.00	1,644,800.00
2105	Нормативт зардал	28,533,740.00	25,060,220.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,530.00	224,430.00
210502	Хоол, хүнс	28,504,210.00	24,835,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,565,000.00
210604	Урсгал засвар		1,565,000.00
2107	Томилолт, зочны зардал		56,000.00
210702	Дотоод албан томилолт		56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,956,980.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,236,980.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,082,875.41	37,527,844.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	601,600.00	1,755,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,481,275.41	35,772,844.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,171,093.78	8,821,286.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	380,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	380,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,007,869.64	5,844,361.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,007,869.64	5,844,361.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,663,224.14	2,596,924.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,663,224.14	2,596,924.57
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-31,657,115.41	104,517,447.74
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-31,657,115.41	104,517,447.74

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-ын хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,763,939.60	220,731,586.30	267,033,183.54	812,528,709.44
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				

5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
8	Тайлант үеийн үр дүн			104,517,447.74	104,517,447.74
9	.....				
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,763,939.60	220,731,586.30	371,550,631.28	917,046,157.18

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	563,799,983.00	556,390,404.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,799,983.00	556,390,404.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	514,169,500.00	511,980,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	514,169,500.00	511,980,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,250,000.00	940,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,250,000.00	730,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,217,200.00	42,217,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,217,200.00	42,217,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,163,283.00	1,253,004.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,163,283.00	1,253,004.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	565,579,463.00	556,390,404.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	565,579,463.00	556,390,404.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540,245,086.22	546,316,113.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,900,799.86	424,233,513.20
210101	Үндсэн цалин	256,174,099.86	264,364,945.00
210102	Нэмэгдэл	124,236,500.00	123,367,186.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,360,000.00	1,172,399.60
210104	Урамшуулал	31,130,200.00	35,328,981.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,885,406.00	57,291,372.23
210201	Тэтгэврийн даатгал	38,301,800.00	41,167,399.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,145,900.00	4,264,599.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,316,700.00	3,078,172.16
210204	Ажилгүйдлийн даатгал	829,200.00	771,517.81
210205	Эрүүл мэндийн даатгал	8,291,806.00	8,009,682.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,209,330.36	34,510,338.14
210301	Гэрэл, цахилгаан	6,252,866.36	7,749,312.14
210302	Түлш, халаалт	14,875,000.00	17,430,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,081,464.00	9,331,026.00

2104	Хангамж, бараа материалын зардал	7,114,800.00	1,347,000.00
210401	Бичиг хэрэг	161,200.00	81,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	130,600.00	295,000.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,507,800.00	662,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	290,200.00	308,500.00
2105	Нормативт зардал	29,108,670.00	24,946,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	187,700.00	75,600.00
210502	Хоол, хүнс	28,390,970.00	24,145,490.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	530,000.00	725,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,876,500.00
210604	Урсгал засвар		1,876,500.00
2107	Томилолт, зочны зардал		56,000.00
210702	Дотоод албан томилолт		56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,956,980.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,236,980.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,069,100.00	2,054,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,069,100.00	2,054,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,334,376.78	10,074,290.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,663,283.00	1,633,004.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,163,283.00	1,253,004.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	380,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,007,869.64	5,844,361.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,007,869.64	5,844,361.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,663,224.14	2,596,924.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,663,224.14	2,596,924.57
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-1,779,480.00	
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах		
	Дотоод эх үүсвэрээр		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,779,480.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	554,197,400.00	545,770,113.57	8,427,286.43	98.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554,197,400.00	545,770,113.57	8,427,286.43	98.48

**Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,197,400.00	545,770,113.57	8,427,286.43	98.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,271,800.00	424,233,513.20	38,286.80	99.99
210101	Үндсэн цалин	256,529,300.00	264,364,945.00	-7,835,645.00	103.05
210102	Нэмэгдэл	126,614,000.00	123,367,186.80	3,246,813.20	97.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,018,100.00	1,172,399.60	2,845,700.40	29.18
210104	Урамшуулал	37,110,400.00	35,328,981.80	1,781,418.20	95.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,652,800.00	57,291,372.23	361,427.77	99.37
210201	Тэтгэврийн даатгал	40,594,300.00	41,167,399.35	-573,099.35	101.41
210202	Тэтгэмжийн даатгал	4,264,600.00	4,264,599.97	0.03	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,411,700.00	3,078,172.16	333,527.84	90.22
210204	Ажилгүйдлийн даатгал	852,900.00	771,517.81	81,382.19	90.46
210205	Эрүүл мэндийн даатгал	8,529,300.00	8,009,682.94	519,617.06	93.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,340,700.00	34,510,338.14	5,830,361.86	85.55
210301	Гэрэл, цахилгаан	11,645,900.00	7,749,312.14	3,896,587.86	66.54
210302	Түлш, халаалт	17,487,700.00	17,430,000.00	57,700.00	99.67
210303	Цэвэр, бохир ус	11,207,100.00	9,331,026.00	1,876,074.00	83.26
2104	Хангамж, бараа материалын зардал	801,000.00	801,000.00		100
210401	Бичиг хэрэг	131,500.00	81,400.00	50,100.00	61.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	106,500.00	295,000.00	-188,500.00	277
210404	Ном, хэвлэл	82,300.00		82,300.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	243,900.00	326,100.00	-82,200.00	133.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	236,800.00	98,500.00	138,300.00	41.6
2105	Нормативт зардал	25,455,600.00	24,946,690.00	508,910.00	98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,600.00	75,600.00		100
210502	Хоол, хүнс	24,654,100.00	24,145,490.00	508,610.00	97.94
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	725,900.00	725,600.00	300	99.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,876,500.00	1,876,500.00		100
210604	Урсгал засвар	1,876,500.00	1,876,500.00		100
2107	Томилолт, зочны зардал	134,400.00	56,000.00	78,400.00	41.67
210702	Дотоод албан томилолт	134,400.00	56,000.00	78,400.00	41.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	935,700.00		935,700.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	935,700.00		935,700.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,728,900.00	2,054,700.00	674,200.00	75.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	416,700.00		416,700.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,312,200.00	2,054,700.00	257,500.00	88.86
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	554,197,400.00	545,770,113.57	8,427,286.43	98.48
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	511,980,200.00	509,383,275.43	2,596,924.57	99.49
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	511,980,200.00	509,383,275.43	2,596,924.57	99.49
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,217,200.00	36,386,838.14	5,830,361.86	86.19

132001	Орон нутгийн төсвөөс	42,217,200.00	36,386,838.14	5,830,361.86	86.19
--------	----------------------	---------------	---------------	--------------	-------

## **2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	940,000.00	940,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,000.00	940,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,000.00	560,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	380,000.00

## **3. Аудитын тайлан**

### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Хэрлэнзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд тодорхойлсон бага насны хүүхдийн өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах сургалтын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАУХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 555,137.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,327.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,828.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104,517.4 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Бараа материал	43,974.6	46,478.4	2,809.8
Үндсэн хөрөнгө	768,554.0	870,567.7	102,013.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>812,528.7</b>	<b>917,046.1</b>	<b>104,517.4</b>
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	812,528.7	917,046.1	104,517.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>812,528.7</b>	<b>917,046.1</b>	<b>104,517.4</b>

Бараа материалын данс 46,748.4 мянган төгрөг болж 2,809.8 мянган төгрөгөөр өссөн нь зарцуулаагүй үлдсэн бараа материалын дансны үлдэгдлээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 870,567.7 мянган төгрөг болж 102,013.7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 917,046.1 мянган төгрөг болж 104,517.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 824,319.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 824,319.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 511,980.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 42,217.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 511,980.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 42,217.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, урсгал үйл ажиллагаанд 546,316.1 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 5,844.3 мянган төгрөг, улсын төсөвт 2,596.9 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 545,770.1 мянган төгрөг буюу 98.48 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

940.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 380.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд, 210.0 мянган төгрөгийг төлбөр хураамжид, 350.0 мянган төгрөгийг ариутгалын зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансанд мэдээлвэл зохих 151 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл, тухайн жилийн төсөв орсон нэмэлт өөрчлөлт хэсгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4,317.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага	1	4,317.3	1	4,317.3			
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	2	4,317.3	2	4,317.3			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,102.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 290.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2,812.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа гараагүй.

### 4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 290.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь ЗГ-ын 43 дугаар тогтоолын 1.4.-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тусгай зориулалттай материал дансанд хөрөнгийн шинж чанартай 1,810.0 мянган төгрөгийн 6 ширхэг тавиурыг бүртгэсэн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн шинж чанартай тавиурыг үндсэн хөрөнгийг холбогдох дансанд бүртгэх

#### 2. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

1. Шилэн дансны мэдээлэлд "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт хэсгийн мэдээллийг" 1,002.9 мянган төгрөгийн мэдээллийг 10 сард хугацаа хоцроож мэдээлсэн.

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж байх, хамаарах тушаал шийдвэрийг иж бүрэн үнэн зөв мэдээлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэг	3	3,102.9	0	0	0	0	1	290.0	2	2,812.9



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 71/21 - ОРА-2022/50/НА-СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 290,000 төгрөгийн ажлын хувцас худалдан авч Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4.-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 22 дугаар цэцэрлэгийн эрхлэгч И.Олзвой, нягтлан бодогч Г.Ариунчимэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... О.ХЭРЛЭНЗАЯА

